



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/54

Хужирт сум

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга  
хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөгөөт хугацаанд чанартай зохион байгуулах тухай” 01 дүгээр албан даалгавар, аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/117 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Мал сүргийг халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг 2023 оны 04 дүгээр сарын 15 ны өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд, 2023 оны төлөвлөгөөт халдваргүйтгэл, Хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, мал эмнэлгийн халдваргүйтгэлийн аян"-ыг 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн сумын хэмжээнд зохион байгуулсугай.

2. Аян зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, мал эмнэлгийн халдваргүйтгэлийн аяны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Отрын бүс нутгаас буцаж ирэх, дамжин өнгөрөх малын шилжилт хөдөлгөөний үед зөвлөн туслах, хяналт тавих үүрэг бүхий хяналтын цэг ажиллуулах, мал амьтны сэг зэмийг устгах, халдваргүйтгэлийн ажилд шаардагдах шатах тослох материал, халдваргүйжүүлэлтийн хувцас хэрэгсэл, ариутгалын бодисоор хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д даалгасугай.

4. Дээрх арга хэмжээг чанартай зохион байгуулан, удирдлага арга зүйгээр хангаж, ажлын үр дүнг Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулхыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Б.Ичинхоролцэвэлмаа) ажлын хэсгийн ахлагч (Б.Дэмбэрэл)-д тус тус үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (З.Цэцэгмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Т.БАЯРМӨНХ